



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ДАЛАНЗАДГАД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 8/4

Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 199 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:


1. “Даланзадгад сумын нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мод, төмс, хүнсний ногоо тарих зориулалтаар газар олгоход баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн мод, төмс, хүнсний ногоо тарих хүсэлтийг хүлээн авч Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороонд хүргүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Х.Батболд)-д даалгасугай.

3. Сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг хянан үзэж эрэмбэлэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар сумын Засаг даргад хүргүүлэхийг Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо (Н.Ариунсанаа)-д даалгасугай.

4. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхийг сумын Засаг дарга (Х.Батболд)-д даалгасугай.

5. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Х.Батболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.МЭНДЭЭ

492201106

Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний  
өдрийн хуралдааны .../7... дугаар тогтоолын  
хавсралт

ДАЛАНЗАДГАД СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ  
БАЙГУУЛЛАГАД МОД, ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО ТАРИХ  
ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ОЛГОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ

НЭГ. ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ ШИЙДВЭРЛЭХ

- 1.1 Иргэн, хуулийн этгээд нь газар эзэмших хүсэлтээ сумын Засаг даргад бичгээр гаргана. Шаардлага хангасан материалыг хүлээн авч бүртгэх, материалыг Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороонд хүргүүлэх ажлыг сумын Засаг дарга хариуцна.
- 1.2 Материалыг тухайн оны 06 дугаар сарын 10-ны өдөр, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороонд хүргүүлсэн байна. Тухайн хугацаанаас хоцорсон материалыг дараагийн хугацаагаар тооцож хүсэлт өгсөн этгээдэд мэдэгдэх.
- 1.3 Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хороо хуралдан ирүүлсэн материалыг хянан үзэж эрэмблэн хоёрдугаар улирлын сүүлийн хуралд оруулах, дөрөвдүгээр улирлын сүүлийн хуралд оруулах материалыг сумын Засаг даргад хүргүүлэх.
- 1.4 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хоёрдугаар улирлын сүүлийн хурлаар хэлэлцэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах 10-15 хүсэлт, дөрөвдүгээр улирлын сүүлийн хурлаар хэлэлцэн газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах 10-15 хүсэлтийг шийдвэрлэх байдлаар 2 удаа тогтоол гарган баталгаажуулна. Жич: Хаяагийн гол, Начинд 10 материал, бусад байршилд 5 газар олгоно гэж ойлгоно.
- 1.5 Тогтоолын хэрэгжилтийг хангаж газар эзэмшүүлэх шийдвэр гарган, гэрээ байгуулан гэрчилгээжүүлэх ажлыг сумын Засаг дарга, Газрын даамал хариуцна.

ХОЁР. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ  
ЗАРЧИМ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 Хүсэлт гаргасан газар нь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн байх шаардлагатай. Мөн төлөвлөгдсөн болон одоо ашиглагдаж буй газар олголт, дэд бүтцийн барилга, байгууламж /зам, бүх төрлийн шугам сүлжээ, ашиглалтын нөөц талбай гм/-тай ямар нэг байдлаар давхцалгүй байх, холбогдох хууль, дүрэмд заагдсан хамгаалалтын бүсийг бүрэн чөлөөлсөн байх, бусад этгээд зорчих гарц, гарамыг нээлттэй байлгах нөхцлийг бүрэн хангасан байх шаардлагатай.
- 2.2 Хүсэлт гаргах газар нь Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ногоон байгууламж байгуулах, хүнсний ногоо тарих тохиромжтой байршил буюу Хаяагийн гол, Начин чиглэлд байх боломжтой



- бөгөөд тухайн байршилд олгох газрыг Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны хурлаас шийдвэрлэнэ. Бусад байршилд газар хүссэн этгээд урьдчилан сумын Газрын даамлаас тодруулан газрын байршлыг нарийн тогтоосон байна.
- 2.3 Нэг этгээдэд эзэмшүүлэх газрын дээд хэмжээ 1 га-аас илүүгүй байна.
  - 2.4 Газар эзэмшигч нь Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын дагуу газрын төлбөрөөс 5 жил бүрэн чөлөөлөгднө. Иймд тухайн хугацаанд буюу газар эзэмшүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд тухайн эзэмшил газрыг бусдад шилжүүлэхгүй, түрээслэх байдлаар бусад этгээдэд ашиглуулахгүй, түрээслэхгүй байх
  - 2.5 Эзэмшил газрын ашигт байдлыг нэмэгдүүлэх, зориулалтын дагуу үйл ажиллагаа тасралтгүй явуулах үүднээс жил бүр 200-аас доошгүй мод тариалах. Тариалсан модны тооллогыг жил бүр хийлгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 199 дүгээр тогтоолын дагуу модны урамшуулалд хамрагдах.
  - 2.6 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд мод тарих үйл ажиллагааг жил бүр тасралтгүй явуулах.
  - 2.7 Эзэмшил газрын 50%-аас багагүй талбайд ногоон байгууламж, мод, модлог ургамал тариалах. Үлдсэн талбайд хүнсний ногоо тарих, хүлэмж байгуулах зэргээр ашиглаж болно.
  - 2.8 Газар эзэмшигч нь эзэмшил газраа хашаажуулах, худаг гаргах, шугам сүлжээнд холбогдох, модны суулгац авах, тариалалт хийх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд газар эзэмшүүлэх шийдвэр гарсан хугацаанаас хойш 1 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлнэ.
  - 2.9 Иргэн, аж ахуйн нэгж, байгуулагатай хийх мод тарих гэрээг байгуулан хэрэгжилтийг жил бүр дүгнүүлэн ажилласан байх. Тогтоолын хавсралтын дагуу

#### ГУРАВ. ХҮСЭЛТ ГАРГАГЧ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- 3.1 Иргэний хүсэлт гар өргөдөл байх, хуулийн этгээдийн хүсэлт албан тоотоор байх шаардлагатай.
- 3.2 Хийх ажлын төсөв, тооцоо бүхий төслийн материал
- 3.3 Хувь хүний болон байгууллагын санхүүгийн чадавхи, түүнийг нотлох баримт /доорх материал дангаараа эсвэл хамт байж болно/
  - 3.3.1 Банкны тодорхойлолт, санхүүгийн баримт гм
  - 3.3.2 Хашааны материал авсан нотолгоо, гаалийн бичиг, бусад баримт /хашааны тор, шон, шургаа гм/
- 3.4 Худаг гаргах эрх бүхий байгууллагатай хийсэн гэрээ /тухайн гэрээ нь худгийг дундаа ашиглахаар хамтын гэрээ байж болно/
- 3.5 Модны суулгац, үр зэргийг худалдан авах гэрээ, авсан бол холбогдох баримт
- 3.6 Өөрийн мод тарих туршлага, эсвэл эзэмшсэн чадавхийг нотлох баримт, ажиллах хүчний нөөц бололцооны судалгаа

#### ДӨРӨВ. ГАЗАР ЭЗЭМШИГЧИД ХОРИГЛОХ ЗҮЙЛ



Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний  
өдрийн хуралдааны .../4... дугаар тогтоолын  
хавсралт

## ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАТАЙ МОД ТАРИХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

... оны ... сарын ...-ны өдөр

Даланзадгад сум

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Нэг талаас Сумын Засаг дарга /цаашид "А" тал гэх/ нөгөө талаас Даланзадгад сумын ..... дугаар баг ..... хаяг /байршил/-д ..... м<sup>2</sup> газар эзэмшигч /цаашид "Б" тал гэх/ ..... нар нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь заалт, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 199 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### ХОЁР. "А" ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Сумын Засаг даргын ..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... дугаар захирамжийг үндэслэн олгогдсон эзэмшлийн газрын бичиг баримтыг олгох
- 2.2. Эзэмшлийн газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт хийх, зориулалтын дагуу үр ашигтай ашиглах талаар шаардах
- 2.3. Тарьсан модны тооллогыг жил бүр хийж, акт үйлдэн зургаар батлгаажуулах
- 2.4. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай материал хүлээн авахгүй, тухайн асуудлаар шийдвэр гаргахгүй байх /5 жилийн хугацаанд/
- 2.5. Харилцан тохиролцсон нөхцлийн дагуу мод тарих ажил хийгдээгүй тохиолдолд дараагийн жил нөхөн тариулах нэг удаагийн сануулга өгөх, 2 жил дараалан гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох

### ГУРАВ. "Б" ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 3.1. Эзэмшлийн газрыг зориулалтын дагуу ашиглах буюу нийт талбайн 70%-аас доошгүй хэсэгт ногоон байгууламж мод тарьж ургуулах
- 3.2. Газар эзэмшигч нь эзэмшил газраа хашаажуулах, худаг гаргах, шугам сүлжээнд холбогдох, модны суулгац авах, тариалалт хийх ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд газар эзэмшүүлэх шийдвэр гарсан хугацаанаас хойш 1 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлнэ. Мөн мод тарих үйл ажиллагааг жил бүр тасралтгүй явуулах.
- 3.3. Жил бүр 200-аас доошгүй мод тарих, тарьсан модны тооллогыг өөрийн хүсэлтээр жил бүр хийлгэж урамшуулалд хамрагдсан байх

- 4.1 Эзэмшил газрыг ямар нэг байдлаар ашиг олох зорилгоор зориулалтын бусаар ашиглах
- 4.2 Энэ журмын 2.4 дэх заалтын дагуу газар эзэмшүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд бусдад шилжүүлэх үйлдэл гаргах
- 4.3 Хүндэтгэн үзэх шалгаангүй тохиолдолд мод тарих үйл ажиллагаагаа тасалдуулах, зогсоох
- 4.4 Газар эзэмшүүлэгчээс хууль, журмын дагуу тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биелүүлэхгүй байх
- 4.5 Хориотой ургамал тариалах

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- 3.4. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай үйлдэл гаргахгүй байх /5 жилийн хугацаанд/
- 3.5. Газар эзэмшүүлэгчээс хууль тогтоомжийн дагуу тавьсан шаардлагыг бүрэн биелүүлэх
- 3.6. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын дагуу газрын төлбөрөөс 5 жил бүрэн чөлөөлөгдөх бөгөөд тухайн хугацаанаас хойш тогтоогдсон төлбөрийг жил бүр бүрэн төлж байх
- 3.7. Шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээд тухайн эзэмшлийн газарт нэвтрэхэд саад учруулахгүй байх

#### **ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ**

- 4.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.
- 4.2. Газрын тухай хуулийн дагуу 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтын дагуу сумын Газрын даамалтай байгуулсан Газар эзэмших гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 4.3. Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг хоёр тал харилцан тохиролцох байдлаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэж чадахгүй бол маргааныг шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

***А талыг төлөөлж:***

Сумын Засаг дарга:

.....

/...../

Сумын Газрын даамал:

.....

/...../

Сумын Байгаль хамгаалагч :

.....

/...../

***Б талыг төлөөлж:***

Газар эзэмшигч:

.....

/...../

Регистрийн дугаар:

.....

Утас: .....